| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,965,397,400.00 | 2,372,321,663.00 | 593,075,737.00 | 80.0 |
| 221001 | Их засвар | 1,365,397,400.00 | 1,155,621,663.00 | 209,775,737.00 | 84.6 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 1,600,000,000.00 | 1,216,700,000.00 | 383,300,000.00 | 76.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **17,118,588,000.00** | **17,225,194,261.84** | **(106,606,261.84)** | **100.6** |
| **1340** | **НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **17,054,489,000.00** | **17,164,454,600.00** | **(109,965,600.00)** | **100.6** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 17,054,489,000.00 | 17,164,454,600.00 | (109,965,600.00) | 100.6 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 64,099,000.00 | 60,739,661.84 | 3,359,338.16 | 94.8 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 37,015,000.00 | 30,252,122.00 | 6,762,878.00 | 81.7 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 27,084,000.00 | 30,487,539.84 | (3,403,539.84) | 112.6 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 1,510,538,381.38 | (1,510,538,381.38) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 2,619,936.64 | (2,619,936.64) | - |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **-** | **-** | **-** | **-** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **-** | **-** | **-** | **-** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **427** | **425** | **2** | **99.5** |
| 620001 | Удирдах ажилтан | 6 | 6 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 279 | 245 | 34 | 87.8 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 142 | 174 | -32 | 122.5 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/** | **-** | **-** | **-** | **-** |
| **64** | **ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО** | **-** | **-** | **-** | **-** |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **427** | **425** | **2** | **99.5** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮЭМ/ | 365 | 358 | 7 | 98.1 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/ | 62 | 67 | -5 | 108.1 |



АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК
Account Trust Audit LLC

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн түргэн тусламжийн төв нь Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн иргэдэд цочмог өвчин эмгэг, осол, гэмтэл, хордлого, жирэмслэлт, төрөлтийн үед эмнэлгийн яаралтай анхны тусламжийг газар дээр нь болон тээвэрлэх явцад үзүүлэх чиг үүрэг бүхий Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Нийслэлийн түргэн тусламжийн төв нь эрхэм зорилгоо "Иргэдэд түргэн тусламжийн үйлчилгээг мэргэжлийн ёс зүйн ур чадвар эзэмшсэн баг цаг алдалгүй, чанартай, хүртээмжтэй үзүүлэхэд оршино" гэж тодорхойлон дараах зорилтыг тавин ажиллаж байна.

- Түргэн тусламжийн стандарт, чанар, аюулгүй байдлыг олон улсын жишигт хүргэсэн үндэсний төв болох;
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үр дүнтэй хүргэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх;
- Байгууллагын хөгжил, удирдлага, хүний нөөцийг чадавхжуулах;
- Санхүүжилт, хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй зарцуулан байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх;
- Шинэ технологи, шилдэг санаа, цахим сүлжээ, инновацыг нэвтрүүлэх.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус төв үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль,Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.Тухайлбал:

- Төсөвийн тухай хуулт
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл /ЭМДҮЗ/-ийн тогтоол 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 06 дугаар тогтоол;
- ЭМДҮЗ-ийн тогтоол 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 07 дугаар тогтоол;
- ЭМДҮЗ-ийн тогтоол 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 08 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тайлант онд тус төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах , дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төв Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,493,852.7 мянган төгрөгөөр буюу 15.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,510,538.4 | 2,619.9 | (1,507,918.5) |
| Авлага | 2,314,250.0 | 4,264,795.4 | 1,950,545.4 |
| Бараа материал | 1,244,797.6 | 1,221,522.6 | (23,275.0) |
| Үндсэн хөрөнгө | 11,457,497.7 | 13,531,998.5 | 2,074,500.8 |
| **Нийт хөрөнгө** | **16,527,083.7** | **19,020,936.4** | 2,493,852.7 |
| Өр төлбөр | 60.0 | 613,434.5 | 613,374.5 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 16,527,023.7 | 18,407,501.9 | 1,880,478.2 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **16,527,083.7** | **19,020,936.4** | **2,493,852.7** |

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс дараах өөрчлөлт гарсан байна. Үүнд:
Мөнгөн хөрөнгө данс- өмнөх оноос 1,507,918.5 мянган төгрөгөөр буурч, 2,619.9 мянган төгрөг болсон байна.

Авлага данс- өмнөх оноос 1,950,545.4 мянган төгрөгөөр өсч 4,264,795.4 мянган төгрөг болсон байна. Авлага дансны үлдэгдэлд төлбөртэй үйлчилгээний 4,173,687.8 мянга, Сити агро ХХК-ийн нийлүүлсэн чанарын шаардлага хангаагүй тоног төхөөрөмжийг буцааснаас үүссэн авлага 81,107.6 мянга, 2 хувь хүнээс авах 10,000.0 мянган төгрөгийн авлага тус тус байна.

Бараа материал данс -тайлант онд худалдан авсан 3,162,715.0 мянга, хандив тусламжаар 82,154.1 мянга, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 12,799.6 мянга, нийт 3,257,668.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 3,076,949.5 мянган төгрөгийн материалыг зарцуулж, 203,994.2 мянган төгрөгийн материалыг актлаж, дансны үлдэгдэл 1,221,522.6 мянган төгрөг болж өмнөх оноос 23,275.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс- тайлант онд 3,062,456.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсны голлох хувийг Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй салбаруудын барилгын их засварын 1,155,621.7 мянга, худалдан авсан 10 автомашины үнэ 1,580,000.0 мянган төгрөг тус тус эзэлж байна. Хандив тусламжаар ирсэн 108,253.5 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэн авснаар нийт 3,170,709.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт 516,164.3 мянган төгрөгийн хөрөнгө акталж, Сити агро ХХК-ийн нийлүүлсэн чанарын шаардлага хангаагүй 81,107.6 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус хассанаар дансны үлдэгдэл 21,352,338.0 мянган төгрөг болсон байна.

Тайлант хугацаанд 1,023,982.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлттэй холбоотой хуримтлагдсан элэгдэлд 525,045.5 мянган төгрөгийн хасагдах өөрчлөлт орсноор үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг 13,531,998.5 мянган төгрөг болсон байна.

Өр төлбөр данс- өмнөх оноос 613,374.5 мянган төгрөгөөр өсч 613,434.5 мянган төгрөг болсон байна. Өглөг дансны үлдэгдэлд бараа, үйлчилгээний зардлын өглөг 434.5 мянга, Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг 613,000.0 мянган төгрөг тус тус байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/данс- тайлант оны үр дүнгийн 1,880,478.1 мянган төгрөгөөр өссөн өөрчлөлт орсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвийг 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /ЭМДЕГ/-аас гүйцэтгэлээр санхүүжилт 20,023,245.70 мянга, үйл ажиллагааны орлогоос 60,739.7 мянга, нийт зарлагыг 20,083,985.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.


АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК
Account Trust Audit LLC

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалаас 17,164,454.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 60,739.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 18,733,037.3 мянган төгрөг буюу 93.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 739,802.7 мянга, харуул хамгаалалтын зардлыг 11,880.0 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж 6,190.0 мянга, нийгмийн зориулалтай барилгын зардлыг 593,000.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | **71601 Нийгмийн эрүүл мэнд** | **20,083,985.4** | **18,733,112.7** | **1,350,872.7** | **93.3** |
| 1.1 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 16,699,208.0 | 15,959,405.3 | 739,802.7 | 95.6 |
| 1.2 | 80219- Харуул хамгаалалтын зардал | 162,000.0 | 150,120.0 | 11,880.0 | 92.7 |
| 1.3 | 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж | 257,380.0 | 251,190.0 | 6,190.0 | 97.6 |
| 1.4 | 80904-Нийгмийн зориулалтай барилга | 2,965,397.4 | 2,372,397.4 | 593,000.0 | 80.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК
Account Trust Audit LLC

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны хуулиудын хэрэгжилт, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2024 оны 1 дүгээр сарын 15-наас 2 дугаар сарын 20-ны хооронд Аккаунт траст аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Замбага, аудитор Р.Цогзолмаа, туслах аудитор П.Саранчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэтуяа, компанийн захирал П.Наранцэцэг нар анхан шатны чанарын хяналтыг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 14,716,702.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 220,750.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор байгууллагын төсвийн захирагч байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан, ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 7 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 139,508.6 мянган төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны хуулийг мөрдөн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилтэй холбоотой зөрчил илрүүлж, зөрчлийг аудитын тайланд тусгалаа.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1 акт тогтоож, 1 албан шаардлага ,3 зөвлөмж өгснийг тус тус 100 хувь биелүүлсэн байна.

*Хүснэгт 4* Зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 3,000.0 | 1 | 3,000.0 | 100.0 |
| Албан шаардлага | 1 | | 1 | | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 42,118.1 | 3 | 42,118.1 | 100.0 |
| **Нийт дүн** | **5** | **45,118.1** | **5** | **45,118.1** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 466,957.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 466,957.2 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- Харилцах дансанд эргүүлэн тушаасан цалингийн зөрүү 7,300.6 мянган төгрөгийг нийтлэг татварын бус орлогоор тайлагнасан;
- Ажил олгогчийн НДШ-ийн зардлын дүнг 116.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Унаа хоолны хөнгөлөлтийн зардлыг 261,663.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Эд хогшил, урсгал засварын зардалд 81,107.6 мянган төгрөгийн багаж хэрэгслийг сөрөг утгатай тайлагнаж зардлын дүнг бууруулсан.

Элгээр алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д " үнэн зөв байх", тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.3-д "бүх өр төлбөр", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийн шаардлагыг хангахгүй байна.

Аудитаар нийт 151,531.5 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 151,531.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

<u>*Илрүүлэлт:*</u>

Тайлант онд худалдан авсан 8 харилцагчийн 151,531.5 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний и баримт цахим системд бүртгэгдээгүй байна.

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Бараа ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ цахим и-баримтыг бүрдүүлж, татварын цахим системийн баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлэх.

**2. Үндсэн хөрөнгийн дансны үнэтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 421 нэр төрлийн 5,753,809.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгааг Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох талаар холбогдох саналыг бэлтгэн Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлж шийдвэрлүүлэх арга хэмжээ авах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Харилцах дансанд эргүүлэн тушаасан цалингийн зөрүү 7,300.6 мянган төгрөгийг нийтлэг татварын бус орлогоор тайлагнасан байна. | 1 | 7,300.6 | - | - | 1 | 7,300.6 | 1 | 7,300.6 | - | - | - | - |
| Ажил олгогчийн НДШ-ийн зардлын дүнг 116.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна. | 1 | 116,885.5 | - | - | 1 | 116,885.5 | 1 | 116,885.5 | - | - | - | - |
| Унаа хоолны хөнгөлөлтийн зардлыг 261,663.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. | 1 | 261,663.6 | - | - | 1 | 261,663.6 | 1 | 261,663.6 | - | - | - | - |
| Эд хогшил, урсгал засварын зардалд 81,107.6 мянган төгрөгийн багаж хэрэгслийг сөрөг утгатай тайлагнаж зардлын дүнг бууруулсан байна. | 1 | 81,107.6 | - | - | 1 | 81,107.6 | 1 | 81,107.6 | - | - | - | - |
| Дүн | 4 | 466,957.3 | - | - | 4 | 466,957.3 | 4 | 466,957.3 | - | - | - | - |



АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК
Account Trust Audit LLC

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд худалдан авсан 8 харилцагчийн 151,531.5 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний и баримт цахим системд бүртгэгдээгүй байна. | 1 | 151,531.5 | - | - | - | - | 1 | 151,531.5 | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 421 нэр төрлийн 5,753,809.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгааг НӨХГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **151,531.5** | **-** | **-** | **-** | **-** | **2** | **151,531.5** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 7 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 139,508.6 мянган төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй байна. | 1 | 139,508.6 | - | - | - | - | 1 | 139,508.6 |
| **Дүн** | **1** | **139,508.6** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **139,508.6** |



АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК
Account Trust Audit LLC